



BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛЫТ ХК



**МОНГОЛ БАЗАЛЫТ ХК-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
2019**

www.basaltwool.mn

ЭРХЭМ ЗОРИЛГО

Инноваци шингэсэн үйлдвэрлэл технологиороо салбараа манлайлан хөгжүүлж, хүний амьдрах орчинг эрүүл тав тухтай, байгаль дэлхийд ээлтэй, барилга хийцийн эрсдэлгүй, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх, ямагт өсөх үнэ цэнэ бүхий баталгаат хөрөнгө оруулалтыг бий болгох

УРИА ҮГ

1 чулууны 7 гайхамшиг

Бидний бүтээгдэхүүний цөмд байгалийн чулууны хүч оршино.



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Компанийн оноосон нэр:	“Монгол Базальт” хувьцаат компани
Байгуулагдсан огноо:	2007
Үйл ажиллагааны чиглэл:	Чулуун хөвөнгийн үйлдвэр
Компанийн албан ёсны хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр, 403 тоот.
	Утас: (976) 7511-4444 Вэб: www.basaltwool.mn E-mail: monbasalt@rockwool.mn Фэйсбүүк: Mongol Basalt JSC

УДИРЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

ТУЗ-ийн дарга:	Л.Ариунболд
Гүйцэтгэх захирал:	А.Энхгэрэл
Ажилчдын тоо:	64

ҮЙЛДВЭРЛЭЛ

Үйлдвэрийн хүчин чадал:	Цагт 1.5 тонн
-------------------------	---------------

КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Монгол Базальт”ХК нь 2007 онд Монгол Улсын анхны чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрээ ашиглалтанд оруулсан.

Бид үйлдвэрээ байгуулахдаа Орос, Герман, Дани, Япон, Хятад зэрэг улсуудын технологи хөгжүүлэлтийн “Эрдэм шинжилгээний байгууллага”-уудтай хамтран ажилласан ба эдгээр улсуудын өндөр технологийн “НОУ ХАУ”-г Монголын базальт чулуунд түшиглэн боловсруулж, өөрийн өвөрмөц орц шийдлийг гарган Монгол Улсын Оюуны Өмчийн Газраар баталгаажуулан патент авсан юм.

Ийнхүү манай компани өнгөрсөн 12 жилийн хугацаанд “BASALTWOOL” брэнд нэрээр дотоодын барилга, аж үйлдвэрийн салбарын хэрэглэгчид болон иргэддээ бүтээгдэхүүнээ нийлүүлж байна.

ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ЗОРИЛТ

2022

● Брэндинг хөгжүүлэлт

- BASALTWOOL® брэндийг зорилтот зах зээлд, хэрэглээний өргөн сонголттой, техникийн давуу шийдэлтэй, үнээр өрсөлдөх чадвартайгаар дотоодын болон гадаадын зах зээлд амжилттай нэвтрүүлэх
- Төв Азийн Базальт Дулаалгын Материалын #1 үйлдвэрлэгч, борлуулагч болох

● Борлуулалт

- 2022 он хүртэл жил бүр дунджаар 45%-ийн өсөлт гарган компанийн нийт борлуулалтыг 14 тэрбум төгрөг болгох
- Гадаад зах зээл дээр BASALTWOOL® брэндийн дистрибьюторын үйл ажиллагааг тэлэх
- 2021 он гэхэд борлуулалтын 50%-60%-ийг гадаадын экспорт бүрдүүлдэг болох
- Дотоод зах зээл дээр тэргүүлэгч байр суурийг тогтоон, дэлхийн жишигт нийцсэн чанар стандарттай бүтээгдэхүүн үйлчилгээг дотоодын хэрэглэгчдэд нийлүүлэх

● Чанар

- Бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоог сайжруулах, олон улсын ISO 9001:2015 стандартыг 2020 он гэхэд нэвтрүүлэх

● Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

- BASALTWOOL® брэндийн 5 бүтээгдэхүүнтэй болох
 - Чулуун хөвөн хавтан / batts /
 - Чулуун хөвөн уян / flexible /
 - Чулуун хөвөн шүршдэг / spray wool /
 - Чулуун хөвөн шугам хоолой / pipe /
 - Чулуун хөвөн шавардлагатай / cement mortar BASALTWOOL® /

БҮТЭЭГДЭХҮҮН


BASALTWOOL - Чулуун хөвөн хавтан



BASALTWOOL - Шугам, хоолойн дулаалга



BASALTWOOL - Файбер хавтан



Шүршдэг - **BASALTWOOL**



BASALTWOOL - Хэсэгчлэн угсрах сандвич



- 

Галд шатдаггүй
-180°C +1,100°C-т тэсвэрлэх тул галын эрсдлээс бүрэн хамгаална
- 

Халуун болон хүйтнээс тусгаарлана
Дулаан дамжуулах коэффициент $k=0.036$ вт/мк
- 

Ус, чийг шингээхгүй
Усны уурын тархалтыг тэсвэрлэх коэффициент $k=1$ буюу агаарынхтай тэнцүү
- 

Гажилганд тогтвортой
90%-ийн харьцангуй чийгшил ба +700°C дахь өөрчлөлт 1%-аас хэтрэхгүй
- 


Дуу чимээг шингээж тусгаарлана
45ДБ-аас дээш тусгаарлана



BASALTWOOL®
ЧУЛУУН ХӨВӨН
ХАВТАН



BASALTWOOL®
ХУЙЛМАЛ ХӨНЖИЛ




BASALTWOOL®
ШУГАМ ХООЛОЙН
ДУЛААЛГА



ШҮҮРШДЭГ
BASALTWOOL®



BASALTWOOL®
ХЭСЭГЧЛЭН
УГСРАХ СЭНДВИЧ



BASALTWOOL®
ХАВТАН
ФАЙБЕР ЦЕМЕНТЭН
ГАДАРГУУТАЙ



2019 онд 9-н нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн ба зах зээлд 113,8 мянган боодол буюу 339,2 мянган м2 чулуун хөвөн, 3,5 мянган метр урт шугам хоолойн дулаалга худалдан борлуулсан байна.

2019 онд 361 аж ахуйн нэгж, 758 иргэнд бүтээгдэхүүн худалдан борлуулсан ба нийт харилцагчдын 85% нь шинэ харилцагч, 76% нь аж ахуйн нэгж байгууллага байлаа.

Бид мөн 18 байгууллагатай 3,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулж хамтран ажилласан байна.



Борлуулалтын орлого, ашгийн үзүүлэлтүүд

Тайлант хугацаанд 1910тн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. Энэ нь технологийн шинэчлэл хийгдсэнээр үйлдвэр 10-14 хоног тасралтгүй хугацаагаар ажиллах боломжтой болсон бөгөөд сүүлийн улиралд нийт бүтээгдэхүүний 51% -г үйлдвэрлэсэн нь 2020 онд бид илүү үр ашигтай ажиллах нөхцөл бүрдсэнийг харуулж байна.



Өмнөх онтой харьцуулахад борлуулалт 30% иар өссөн байна.

2019 онд техник тенологийн шинэчлэлийн ажлууд хийгдэж байгаа ч ашигт ажиллагаагаа 54% иар нэмэгдүүлж чадлаа. Цэвэр ашиг 335 сая.төг байгаа нь нэгж хувьцаанд EPS=5.94 төг байна.

Санхүү байдлын тайлангийн гол үзүүлэлтүүд

Тайлант оныг өнгөрсөн онтой харьцуулан анхаарал татах өсөлтүүдийг авч үзвэл урьдчилж олсон орлого 512 сая.төг-өөр нэмэгдсэн нь томоохон хэмжээний бүтээн байгуулалтыг хийж буй барилгын компаниуд урьдчилгаа төлж гүйцэтгэл хийгдэх гэрээнүүд хийгдсэн.



Инженер техникийн албаны онцлох ажлууд

Хайлах зууханд сифон суурьлуулан улалгааны системийг сайжруулсанаар үйлдвэрийг 10-14 хоног буюу 240-336 цаг тасралтгүй ажиллуулж, төлөвлөгөөний дагуу ажиллаж хэвшсэн.

Түүхий эд, цавуу, химийн бодис бусад материалын татан авалтыг богино хугацаанд төлөвлөн татан авч байна.

Авагч талд хөргөлтийн шинэ конвейр суурьлуулан, пакетлагчийг ойртуулан хүн цагийг 1 ээлжинд 1-2 хүнээр хэмнэсэн.

Цавууны форсункны системийг сайжруулан шинэчилсэн.

Пакетлагчын системийн сайжруулалт засвар үйлчилгээг тогтмолжуулсанаар баглаа боодлын хорогдол эрс багассан.

Түүхий эдийн функеруудын доор шигшүүр тор тавьсанаар түүхий эд зуух руу шороотой орохоо больж зуухны ажиллагаа тогтворжсон.

Түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүний жингийн системийг сайжруулсан.

Дизель зуухны засвар үйлчилгээг стандартын дагуу хийлгэж дизель зуухны түлшний зарцуулалтыг 15-20%-иар бууруулсан.



Зуухны галыг хуучин модоор асаах системийг өөрчилж дизель буугаар асаах системд шилжүүлсэнээр асаалтын зардал цаг хугацааг хэмнэсэн.

Бутлуураас гарсан 2-р зэрэглэлийн жижиг фракцтай шохойн чулууг үйлдвэрлэл зууханд ашиглаж шохойн чулууны зарцуулалтын хэмнэлтийг хийсэн.

Технологийн шинэчилсэн зааварыг боловсруулж батлуулсан.

Оёмол хөнжлийн машиныг үйлдвэрлэлд нэвтрүүлж технологийн паспорт ажиллуулах заавар хийсэн.

Зуухны ачаа гулсуурын системийг сайжруулж түүхий эдийн зуухны дотор буулт хайлалтын төвөө олсоноор зуухны ажиллагаа сайжирсан.

Үйлдвэрт мэргэжлийн байгууллага авчирч дуу авиа ажлын байрны нөхцөлийг тодорхойлуулсан.

Үйлдвэрийн хөдөлмөр хамгаалал ажилчдын ажиллах аюулгүй байдлыг хангахаар аюулгүйн кант тэмдэг тэмдэглэгээ татах ажилууд хийгдсэн.

Түүхий эд базальт бэлтгэл, шохойн чулууны бэлтгэл ажлыг уурхайд дээр цагаалуулж бутлуулж татан авалтыг хийж гүйцэтгэж байна.





Компанийн оффисын өргөтгөлийн 2 давхар 96м2 барилгыг 58,680,000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар зураг төсөл төсвийн дагуу гүйцэтгэж ашиглалтанд оруулсан.

Үйлдвэрийн ажилчдын эрүүл ахуйн орчныг сайжруулах зорилгоор 120м2 байрыг 67,600,000

төгрөгийн хөрөнгө оруулалтаар зураг төслийн дагуу гүйцэтгүүлж ашиглалтанд оруулж, тохижуулж бэлэн болгосон.

Инженер техникийн ажилчдын 24м2 өрөөг үйлдвэрийн ашиглагддаггүй талбайд бариулж 16,440,000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар орох, гарах шат, дулаан цахилгааныг шийдэж ашиглалтанд оруулсан.


Гал тогооны байрыг 12,2м2-аар өргөтгөж 26,400,000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж шинээр авч урсгал болон хэсэгчилсэн засварын ажлуудыг хийж гүйцэтгүүлсэн.



Компанийн гаднах төв хаалгыг том оврын автомашин чөлөөтэй нэвтрүүлэх зорилгоор 13,336,000 төгрөгөөр бүрэн шинэчлэж, талбайг бетондож тохижуулсан.

Вагранк зуухны барилгыг 328м2-аар өргөтгөж 10,600,000 төгрөгөөр хаалга, цонх, хана, дээврийг бүрэн сольж дулаалах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Үйлдвэр болон үйлдвэрийн ажилчдын эрүүл ахуй орчныг сайжруулах байрыг 76,5 метр төвийн дулаан, цэвэр усны шугамд холбох ажлыг хийж гүйцэтгүүлэх ажилд 76,514,300 төгрөгийн хөрөнгө оруулалт хийв.



2019 онд хөдөлмөрийн нөхцөл сайжруулах техник технологийн шинэчлэлд 2223362.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг зарцуулсан.

WORK SAFETY



2019 онд компанийн хөдөлмөрийн нөхцөл сайжруулах эрүүл мэнд нийгмийн хамгаалал хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг сайжруулахад 112315,4 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд


Монголын эмэгтэйчүүдийн сан ТББ, өндөр настан Өөдөс, эмзэг бүлгийн иргэн У.Ариунболд нарт нийт 53,9 сая төгрөгийн ажлыг өөрийн болон захиалагчийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн байна.



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ЕБС 5 дугаар сургууль, 22-р цэцэрлэг, 19-р хорооны өрхийн эмнэлэг болон 100 гаруй өрхийн дулааны алдагдлыг хэмжиж, дүгнэлт гарган зөвлөлгөө мэдээлэл өгөх ажилд 5,600,000 төгрөг зарцуулсан байна.



Барилга Хот Байгуулалтын Яам-ны захиалшаар Чингэлтэй дүүргийн 8,9,10-р хороонд хэргэжсэн “Шинэ хороо” төслийн хүрээнд 53 айлын ажлыг дуусган амжилттай хүлээлгэн өгсөн.



МУИС, ШУТИС, МҮИС, БТК, БК-ийн оюутнуудын дадлагын хугацаанд хүлээн авч үйлдэврлэлийн үйл ажиллагаа процесстой танилцуулах, Монгол-Германы хамтарсан техникийн коллежийн дадлагажигч оюутнуудыг ажлын байраар хангаж, дадлагын хугацаанд 2,000,000/хоёр сая/ төгрөгийн тэтгэмж олгон дэмжиж ажиллалаа.



Нийгмийн хариуцлагын хүрээнд



GIZ /Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг/ -аас санаачлан хэрэгжүүлж байгаа “БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛ” төсөлд 50,000 еврогийн санхүүжилт гарган хамтрагчаар оролцож байна.

Хамтарсан төслийн зорилго нь Монгол улсын барилгын салбарт мэргэжлийн боловсрол, сургалт болон түүний чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх явдал юм.

Төлөвлөгдсөн арга хэмжээнүүд нь сургалтын байгууллага болон үйлдвэрлэл дээрх сургалт, цаашдын боловсролыг хөгжүүлэн өргөжүүлэх, нөөц, эрчим хүчний хэмнэлттэй барилгын технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн юм.

Оюутнуудын дадлагын хугацаанд олж авах мэдлэг, чадварыг дээшлүүлэх, үндэсний үйлдвэрээ дэмжих сэтгэлгээг хөгжүүлэх, бүтээлчээр ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол - Германы хамтарсан техникийн коллежийн дадлагажигч оюутнуудыг ажлын байраар хангаж, дадлагын хугацаанд 1,000,000 /нэг сая/-ийн тэтгэмж олгон дэмжиж ажиллалаа.

Монголын эмэгтэйчүүдийн сангийн захиалгаар өрх толгойлсон эмэгтэйчүүдийг дэмжих, тэдний амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эрүүл ахуйн баталгаат эко жишиг орчин бий болгох зорилгоор компанийн өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг ашиглан 40м2 орон сууцыг 1 сарын дотор барьж байгуулан ашиглалтанд оруулаад байна.



Байгальд ээлтэй эко технологиор үйлдвэрлэгдсэн “BASALTWOOL” нэрийн бүтээгдэхүүний хэрэглээ, ач холбогдлыг сурталчлах зорилгоор компанийн ажилтнуудын болон нийт хүүхдүүдийн дунд гар зургийн уралдааныг зохион байгуулж, оролцогчдыг шагнаж урамшуулж, хүүхдийн баярын арга хэмжээг “Мишээл экспо” төвд байрших компанийн SHOW ROOM-д амжилттай зохион байгууллаа.



Co-funded by
the European Union



switchasia



CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION

geres
ACTING FOR
CLIMATE
SOLIDARITY

Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдэд эрчим хүчний хэмнэлтийн талаар зөвлөгөө өгөх, санхүүгийн байгууллагад зуучлах иргэдийн чадавхийг бэхжүүлэх төсөл

GERES олон улсын байгууллагын санаачлан хэрэгжүүлж байгаа “ДУЛААН ШИЙДЭЛ” төсөлд хамтрагчаар оролцож байна.

Дулаан тусгаарлагч материал үйлдвэрлэгчийн хувьд амины орон сууцуудын дулааны алдагдлыг бууруулах, нүүрсний хэрэглээг багасгах зорилгоор “Эрчим хүчний хэмнэлтийн тухай” Монгол Улсын хууль, “Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-т нийцүүлэн “ДУЛААЛГА АЯН”-ыг эхлүүлэн төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдтэйгээ хамтран ажиллан тодорхой үр дүнд хүрч байна.



Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн захиалгаар хийгдсэн 1400 метр дулааны төв шугамын дулаалгын ажлын үйлдвэрлэл, тээвэрлэлт, угсралтын ажлыг хийж хүлээлгэн өгсөн.



Бид Дэлхийн банкны санхүүжилтээр 2017 оноос эхэлсэн Нийслэлийн цэвэр агаар төсөлтэй жил бүр хамтран ажилласаар байна.


Мишээл Барилгын их дэлгүүрт байрлах “BASALTWOOL” сургалт, зөвлөмжийн төвд Нийслэлийн дүүргүүдийн удирдлага, хорооны Засаг дарга нар болон төвийн дүүргийн 50 гаруй гэр хороодын 15 мянга гаруй өрхийн тэргүүн, иргэдэд зохион байгуулалттайгаар үзүүлж, байшин орон сууцыг хэрхэн дулаалах сургалт зөвлөмжийг тогтомог бгч байна.



Дулаалгын материалын төлбөрийг нэг дор төлөх боломжгүй, хуримтлал үүсгэж чадаагүй гэр бүл иргэдэд дулаалганд зориулсан, санхүүгийн дарамт болохооргүй бага хүүтэй ногоон зээлийг авах боломжыг “ХААН банк, ХАС банк, Төрийн банкуудтай хамтран ажиллан олгож байна.



БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“Монгол Базальт”ХК-ийн хувьд компанийн засаглал гэдэг нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг үнэ цэнэтэй, үр өгөөжтэй болгохын тулд нийт Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талууд хоорондын итгэлцэл, бүхий л харилцаа, үүрэг, хариуцлагын зохистой харьцааг тогтооход чухал ач холбогдолтой үйл явц, тогтолцоо юм.

Компани нь компанийн засаглалын чухал хэмжүүр болох ил тод байдлаа улам сайжруулан төгөлдөржүүлэхээр зорин ажиллаж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“Монгол Базальт”ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал /ХЭХ/ бөгөөд ХЭХ нь ээлжит болон ээлжит бус гэсэн хоёр хэлбэртэй байна. ХЭХ-ийг Төлөөлөн удирдах зөвлөл болон “Компанийн тухай хууль” болон компанийн дүрэмд заасан үндэслэлээр зарлан хуралдуулж болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь “Компанийн тухай хууль” болон “Монгол Базальт” ХК-ийн дүрэмд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага юм.

ТУЗ нь компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна хувьцаа эзэмшигчдийн эрхийг компанид төлөөлөн хамгаалдаг.

ТУЗ нь жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг тогтмол хянан, холбогдох үүрэг, чиглэлийг гүйцэтгэх удирдлагад өгч ажилладаг.

“Монгол Базальт” ХК-ийн одоогийн ТУЗ нь 2019 оны 04 сарын 29-ны өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдон ажиллаж байна.

ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар Б.Амарбаясгалан 2018 оноос ажиллаж байна.

ТУЗ нь дэргэдээ дараах 3 дэд хороотой үйл ажиллагаагаа явуулж ба “Монгол Базальт” ХК-ийн 2019 оны 6 сарын 5-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэлдэхүүнтэй томилогдон ажиллаж байна.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

1. Аудитын хороо

Дарга: Ч. Зоригтбаатар, гишүүд: Б.Шаравсамбуу, Т.Цэнд-Аюуш

2. Нэр дэвшүүлэх хороо

Дарга: Ш.Энхтөр, гишүүд: Хан Гю Бунг, Т.Цэнд-Аюуш

3. Цалин урамшууллын хороо

Дарга: Л.Ариунболд, гишүүд: Ч.Зоригтбаатар, Ш.Энхтөр



ШАРАВСАМБУУ ЭНХТӨР

Мэргэжил:

Эрх зүйч, Банкны Удирдлага



ЧАНСАА ЗОРИГТБААТАР

Мэргэжил:

Хуульч, Эдийн засагч



ТҮВШИНТӨР ЦЭНД-АЮУШ

Мэргэжил:

Бизнесийн удирдлага,
Компанийн засаглалын эксперт,
Эдийн засагч

Ердийн гишүүд



ЛХАГВАЖАВ АРИУНБОЛД

Мэргэжил:
Цахиурын исэлд суурилагдсан эрдэсийн хайлах болон дулаанаар боловсруулах технологийн үйлдвэрийн инженер, Эдийн Засагч



АРИУНБОЛД ЭНХГЭРЭЛ

Мэргэжил:
Үйлдвэр Үйл ажиллагааны Менежмент, Санхүү Менежмент



ГАЛБАДРАХ ГАНЗОРИГ

Мэргэжил:
Цэргийн командлагч, Улс төр судлаач



БАДРАХ ШАРАВСАМБУУ

Мэргэжил:
Нягтлан бодогч, Гавьяат Эдийн засагч, / PhD Доктор цол, Эдийн Засгийн Ухааны Доктор /



ПҮРЭВБАНЗРАГЧ САЙНБИЛЭГ

Мэргэжил:
Технологийн Инженер, Санхүүч



HAN KYU BONG /ХАН ГЮ БУНГ/

Мэргэжил:
Бизнес удирдлагын мастер

Гүйцэтгэх удирлагын баг

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
АРИУНБОЛД ЭНХГЭРЭЛ



Д.САЙНБААТАР

Албан тушаал: Ерөнхий Менежер
Мэргэжил: Инженер Эдийн Засагч,
Бизнес удирдлага



Б.НАРАНГЭРЭЛ

Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч
Мэргэжил: Мэргэшсэн Нягтлан Бодогч,
мэргэшсэн аудитор



КОРГАНЦЕВ СЕРГЕЙ ГЕННАДЬЕВИЧ

Албан тушаал: Үйлдвэр эрхэлсэн захирал
Мэргэжил: Технологийн инженер



П.БААСАН-ОЧИР

Албан тушаал: Үйлдвэрийн дарга, ерөнхий технологич
Мэргэжил: Технологийн Инженер мэргэжилтэй.



Х.БАТДЭЛГЭР

Албан тушаал: ИТА-ны ерөнхий инженер
Мэргэжил: Цахилгааны инженер



Ц.БАЙГАЛМАА


Албан тушаал: Дотоод хяналтын ажилтан
Мэргэжил: Нягтлан Бодогч/Дотоод хяналтын
мэргэшсэн аудитор



2019 онд шинээр эдийн засагч, тооцооны нягтлан бодогч, дотоод аудитор, үйлдвэрийн инженер технологич, борлуулалт маркетингийн мэргэжилтэн, сургалт зөвлөлгөө хариуцсан инженер, үндсэн хөрөнгө бараа материалын нярав, ээлжийн тогооч, гал тогооны туслах ажилтан, автын механик инженер, засварын механик, цахилгааны техник, центрфугийн засварчин, ачаалагчийн оперотор зэрэг ажлын байрыг шинээр бий болгож, нийт 15 хүнийг ажлын байраар хангасан.

Компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, чадавхийг дээшлүүлэх, хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэлтийн ажлын хүрээнд “BIZNETWORK” ажлын байрны зарын нэгдсэн сайт болон нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сантай байнгын хамтран ажиллаж, хэрэгцээт ажлын байрны захиалга, идэвхижүүлэлтийг тасралтгүй явуулснаар 2019 оны хаврын төгсөгчдөөс мэргэжлийн ажилтан 1, инженер техникийн ажилтан 3, санхүү бүртгэлийн ажилтан 1, нийт 5 ажилтан шинээр ажилд авч дадлагажуулан ажиллуулж байна.

2019 онд шинээр эдийн засагч, тооцооны нягтлан бодогч, дотоод аудитор, үйлдвэрийн инженер технологич, борлуулалт маркетингийн мэргэжилтэн, сургалт зөвлөлгөө хариуцсан инженер, үндсэн хөрөнгө бараа материалын нярав, ээлжийн тогооч, гал тогооны туслах ажилтан, автын механик инженер, засварын механик, цахилгааны техник, центрфугийн засварчин, ачаалагчийн оперотор, бүтээгдэхүүн авагч зэрэг ажлын байрыг шинээр бий болгож, нийт 20 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна.





Монгол улсын Засгийн Газар,
БОАЖЯ-аас ногоон технологи, ногоон
инноваци нэвтрүүлэгч байгууллага
“НОГООН ГЭРЧИЛГЭЭ”



Монгол Улсын Засгийн Газар,
Барилга Хот Байгуулалтын Яам

**БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН 2019 ОНЫ
ШИЛДЭГ ААН БАЙГУУЛАГА**



“Барилга-Орон сууц-2019”
**ШИЛДЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧ
/БАРИЛГЫН МАТЕРИАЛ/**



“Монголын эмэгтэйчүүдийн сан”
ОНЦЛОХ ХАНДИВЛАГЧ



“Улаанбаатар барилга 2019”
БАРИЛГЫН МАТЕРИАЛ, ШИНЭ ТЕХНИК ТЕХНОЛОГИ

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Симбол: MSE:MBW | Код: 544

Хувьцааны ханш >>> Хаалтын ханш: **▲ 258.73₮ +17.65₮ (+7.32%)**
(2019.12.31)

“Монгол Базальт”ХК-ийн хувьцааны ханш дотоодын хөрөнгийн зах зээл дээр идэвхитэй арилжигдаж, хувьцааны ханш өмнөх оноос өсөлт үзүүлээ. Энэхүү өсөлт нь тайлант хугацаанд МХБирж дээр өндөр өсөлт үзүүлсэн хувьцааны нэгд багтав. Хувьцааны дээд ханш нь 360.32₮, доод ханш 230.53₮, дундаж ханш 236₮ байлаа.

Хувьцааны арилжаа

Тайлант хугацаанд үнэт цаасны хоёрдогч зах зээл 3.34 сая ширхэг хувьцаа 970.7 сая төгрөгөөр арилжигдлаа. Хөрөнгө оруулагчдын бүтцийг харвал 96% нь гадны хөрөнгө оруулагчид байгаа бол 4% нь дотоодын тоглогчид байв.

Зах зээлийн үнэлгээ >>> **▲ 14.6 тэр.төг +995.76 (+7.32%)**
(2019.12.31) /сая.төг/

Жилийн эцсийн байдлаар “Монгол Базальт”ХК-ийн үнэлгээ нь нийт зах зээлийн үнэлгээний 0.54%-ийг эзэлж байна.


Хувьцаа эзэмшигчид

“Монгол Базальт” ХК нь 2019.12.31-ний өдрийн байдлаар 2,258 хувьцаа эзэмшигчтэй байгаа ба 5%-аас дээш хувь эзэмшдэг 5 хувьцаа эзэмшигч, 5%-аас бага хувьцаа эзэмшдэг 2,253 хувьцаа эзэмшигч байна.

Нийт хувьцаа эзэмшигчдийн 2% нь гадны хөрөнгө оруулагчид байгаа нь бусад компаниудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм.




5%-аас дээш эзэмшигчид **70.0%**



5%-аас бага эзэмшигчид **30.0%**

Монголын хөрөнгө оруулагчид **98%**



Гадаадын хөрөнгө оруулагчид **2%**

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

('000 төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2018.12.31	2019.12.31
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	3,909,193	2,156,825
Дансны авлага	322,465	297,126
Татвар, НДШ-ийн авлага	-	132
Бусад авлага	40,001	52,533
Бараа материал	652,795	740,533
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,594,738	3,056,759
Эргэлтийн хөрөнгийн дүн	6,519,191	6,303,908
Эргэлтийн бус хөрөнгө	-	-
Үндсэн хөрөнгө	19,993,301	12,965,867
Биет бус хөрөнгө	2,802,385	10,891,832
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	22,795,686	23,857,700
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	29,314,877	30,161,607
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	-	-
Өр төлбөр	-	-
Богино хугацаат өр төлбөр	-	-
Дансны өглөг	130,141	31,567
Цалингийн өглөг	-	-
Татварын өр	149,119	286,577
НДШ-ийн өглөг	-	-
Банкны богино хугацаат зээл	1,195,827	-
Ногдол ашгийн өглөг	-	130,323
Урьдчилж орсон орлого	18,000	529,809
Бусад богино хугацаат өр төлбөр	203,400	100,316
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,696,488	1,078,592

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /ҮРГЭЛЖЛЭЛ/

('000 төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2018.12.31	2019.12.31
Урт хугацаат өр төлбөр	-	1,951,916
Урт хугацаат зээл	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	1,951,916
Өр төлбөрийн нийт дүн	1,696,488	3,030,509
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	-	-
Өмч	-	-
б) хувийн	5,641,700	5,641,700
в) хувьцаат	-	-
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	20,509,765
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	21,145,916	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал	830,774	979,633
Эздийн өмчийн дүн	27,618,389	27,131,099
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	29,314,877	30,161,607

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

('000 төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2018.12.31	2019.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)	3,478,296	4,270,599
Борлуулалтын өртөг	2,640,415	2,908,268
Нийт ашиг (алдагдал)	837,880	1,362,330
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	339,791	278,589
Бусад орлого	16,461	8,708
Борлуулалт, маркетингийн зардал	452,871	560,750
Ерөнхий ба удирдлагын зардал	407,200	534,765
Бусад зардал	80,801	167,620
Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	-2,116	3,955
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	251,145	390,447
Орлогын татварын зардал	33,979	55,411
Татварын дараах ашиг (алдагдал)	217,166	335,036
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	217,166	335,036

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

('000 төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2018.12.31	2019.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	3,453,459	4,653,164
Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсэний орлого	3,452,125	4,653,014
Бусад мөнгөн орлого	1,334	150
Мөнгөн зарлагын дүн	4,945,319	5,039,740
Ажилчдад олгосон мөнгө	344,937	685,367
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	97,633	223,215
Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	2,291,484	2,464,994
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	85,400	1,064
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	354,662	409,048
Хүүний төлбөрт төлсөн мөнгө	237,317	167,147
Татварын байгууллагад төлсөн мөнгө	540,311	461,706
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	9,707	9,996
Бусад мөнгөн зарлага	983,868	617,204
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,491,860	-386,576
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн	339,791	278,589
Хүлээн авсан хүүний орлого	339,791	278,589
Мөнгөн зарлагын дүн	936,977	2,357,537
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	935,627	2,347,249
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,350	10,288
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-597,185	-2,078,949
Мөнгөн орлогын дүн	8,527,568	5,473,945

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /ҮРГЭЛЖЛЭМ/

('000 төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2018.12.31	2019.12.31
Мөнгөн орлогын дүн	8,527,568	5,473,945
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,692,476	5,465,000
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,835,064	0
Төрөл бүрийн хандив	0	4,210
Бусад орлого	28	4,735
Мөнгөн зарлагын дүн	2,644,590	4,760,790
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,264,843	4,708,911
Төлсөн ногдол ашиг	0	51,099
Валютын хашийн тэгшитгэлийн алдагдал	2,145	780
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	5,882,979	713,156
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,793,933	(1,752,369)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	115,260	3,909,193
Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,909,193	2,156,825

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

('000 төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	3,949,191	-	613,608	21,666,603
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	3,949,191	-	613,608.	21,666,603
Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	-	217,166	217,166
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	1,692,509	-	-	5,734,621
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,641,700	21,145,915.5	830,774	27,618,389
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	5,641,700	21,145,916	830,774	27,618,389
Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	-	335,036	335,036
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-636,150	-	-636,150
Зарласан ногдол ашиг	-	-	-186,176	-186,176
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,641,700	20,509,765	979,633	27,131,099



 **BASALTWOOL®**
МОНГОЛБАЗАЛТ ХК

Маргаашийн хөгжлийг өнөөдөр хамтдаа бүтээнэ...